



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2025 оны сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.8, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1.“Захиргааны хэм хэмжээний акт шинэчлэн батлах тухай” Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 635 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт “Даатгалын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ”-г шинэчлэн энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар, хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх хуваарийг энэ тогтоолын 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан хуваарийн дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд тавигдах шаардлагыг хангаж ажиллахыг 2025 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө тусгай зөвшөөрөл авсан даатгалын компаниудад үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /С.Цогтгэрэл/-нд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

Санхүүгийн зохицуулах хорооны
2025 оны ... сарын ... өдрийн
... тогтоолын 1 дүгээр хавсралт

Санхүүгийн зохицуулах хорооны
2024 оны 635 дугаар тогтоолын
3 дугаар хавсралт

**ДААТГАЛЫН КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН
ХӨРӨНГИЙН ДООД ХЭМЖЭЭ**

№	Даатгалын компанийн үйл ажиллагааны ангилал, чиглэл	Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ
1	Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх компани	15 тэрбум төгрөг
2	Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх компани	15 тэрбум төгрөг
3	Давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх компани	30 тэрбум төгрөг

--oo0oo--

Санхүүгийн зохицуулах хорооны
2025 оны ... сарын ... өдрийн
... тогтоолын 2 дугаар хавсралт

**ДААТГАЛЫН КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ДООД
ХЭМЖЭЭГ ҮЕ ШАТТАЙГААР НЭМЭГДҮҮЛЭХ ХУВААРЬ**

(сая төгрөгөөр)

Огноо	Ердийн даатгалын компани	Урт хугацааны даатгалын компани	Давхар даатгалын компани
2026.06.01	10,000	8,000	25,000
2027.06.01	15,000	10,000	30,000
2028.06.01	-	15,000	-

--oo0oo--



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2025 оны сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.8, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 3.1 дэх хэсгийн “20.0 (хорин)” гэснийг “80.0 (ная)”, “70.0 (далан)” гэснийг “150.0 (зуун тавь)” гэж, 4.1 дэх хэсгийн “10.0 (арван)” гэснийг “40.0 (дөч)” гэж, “7.0 (долоо)” гэснийг “20.0 (хорь)” гэж тус тус өөрчилсүгэй.

2. 2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор “Даатгалын багц дүрэм”-д зааснаас багагүй хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлсэн байхыг даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /С.Цогтгэрэл/-нд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ